



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 8/42

Улаанбаатар хот

Зоонозын халдвар хариуцсан багийн ажиллах журам батлах тухай

Монгол Улсын Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын "Зоонозын өвчнөөс нийтийн эрүүл мэндийг хамгаалах, хамтарсан зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай" 2019 оны А/449, А/544 дүгээр хамтарсан тушаал, Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөө батлах тухай" 2022 оны А/528 дугаар тушаал, "Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дүрмийн 3.2, 4.5 дахь заалтууд, Удирдлагын зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зоонозын халдвар хариуцсан багийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

2. Зоонозын халдвар хариуцсан багуудын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны дарга (Х.Ариунболд), Лавлагаа лабораторийн албаны дарга (У.Өнөрсайхан) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Зоонозын халдвар хариуцсан багуудын үйл ажиллагаанд шалгуур үзүүлэлтийн дагуу бүтэн жилээр үнэлгээ хийж ажиллахыг Чанар, аюулгүй байдал, хяналт үнэлгээний албаны дарга (Б.Ичинхорол)-д, урамшууллыг холбогдох зардлаас тооцон олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Болормаа)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны албаны дарга (У.Нямжаргал)-д даалгасугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан төвийн захирлын 2018 оны А/04 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.АМГАЛАНБАЯР

महानि

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн
Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгчийн
2025 оны ...11... дугаар сарын 19...-ний өдрийн
... дугаар тушаалын хавсралт



ЗООНОЗЫН ХАЛДВАР ХАРИУЦСАН БАГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү журмын зорилго зоонозын халдварыг хариуцан ажиллах эмч, мэргэжилтэнг багаар ажиллуулах, үйл ажиллагааг бэхжүүлэх, зохицуулахад оршино.

1.1 Зоонозын халдвар хариуцсан баг нь Монгол улсад зонхилон тохиолдох нутагшмал, анзаарагддаггүй буюу судлах шаардлагатай, зөөвөрлөгдөх эрсдэлтэй зоонозын өвчнөөс эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг оновчтой зохион байгуулах, мэргэшсэн хүний нөөцийг хөгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй нэгж мөн.

1.2 Зоонозын халдвар хариуцсан багийн гишүүд хамтран ажиллахдаа шударга байдал, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг баримтлан ажиллана.

1.3 Зоонозын халдвар хариуцсан баг нь үндэсний хэмжээнд зоонозын өвчний хяналт сэргийлэлт тусламж, үйлчилгээг үзүүлэх мэргэшсэн халдвар судлагч, нян судлаач, вируслогич, амьтан судлаач, паразитологич, эсийн генетикч, биотехнологич, биохимич, лаборант зэрэг мэргэжилтнүүдээс бүрдэнэ.

1.4 Зоонозын халдвар хариуцсан багийн ахлагчаар зоонозын өвчний чиглэлээр мэргэшүүлэх, дээшлүүлэх сургалтад хамрагдсан, уг халдварын чиглэлээр голомт, дэгдэлт, судалгаанд оролцсон ажлын туршлагатай мэргэжилтнийг багийн гишүүдийн саналаар сонгоно.

1.5 Зонхилон тохиолдох нутагшмал, анзаарагддаггүй буюу судлах шаардлагатай, зөөвөрлөгдөх эрсдэлтэй зоонозын өвчнүүдийг Зоонозын халдвар хариуцсан багуудад хариуцуулна. Үүнд:

1-р баг: Галзуу, бартонеллёз, лептоспироз, Крым-Конгийн цусархаг хам шинж, Орф вирус, бэтэг, фасциолёз, ташуур хорхойтох, лейшманиоз, лямблитах, MERS-CoV, АЦХаХ, ковид-19, сармагчны цэцэг

2-р баг: Тарваган тахал, хулгана тахал, эризепелойд, пастереллёз, листериоз, хуурмаг сүрьеэ, иерсиниоз, ханта вирус, непах вирус, Эбола, гахайн туузан хорхойдох, балантидиаз, холер, Марбургийн цусархаг чичрэг, легионеллийн өвчин

3-р баг: Бруцеллёз, боом, татран, хуурамч ям, ям, хендра вирус, шүлхий, хүж хорхойдох, токсоплазмоз, криптоспориоз, шувууны томуу, ласса

4-р баг: Хачигт боррелиоз, хачигт риккетсиоз, хачигт энцефалит, кампилобактерт энтерит, эрлихиоз, ку чичрэг, баруун Нилийн чичрэг, Япон энцефалит, үхрийн туузан хорхойдох, бабезиоз, анаплазмоз, шар чичрэг, Зика, Чикунгунья, Денгийн чичрэг, хумхаа

1.6 Баг бүр улирал тутамд хариуцсан халдварын чиглэлээр тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хэлэлцүүлэг хурал хийнэ.

1.7 Баг нь хариуцсан зоонозын халдварын чиглэлээр тухайн жилд хийх ажлын төлөвлөгөөг Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын алба, Лавлагаа лабораторийн албаны дарга нараар хянуулж, төвийн захирлаар 1 дүгээр сард батлуулан хэрэгжүүлж ажиллана.

1.8 Бүтэн жилээр баг бүр ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийг удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж дүгнүүлнэ.

1.9 НЭМТШУА-ны дарга зоонозын халдвар хариуцсан багийн бүрэлдэхүүнийг орон тооны шилжилт хөдөлгөөнтэй уялдуулан жил бүр 1 дүгээр сарын эхний 7 хоногт тушаалаар шинэчлэн томилгоожуулна.

1.10 Тухайн зоонозын халдварын чиглэлээр гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зоонозын халдвар хариуцсан багт хариуцуулна.

1.11 Гадаад, дотоодод тухайн халдварын чиглэлээр зохион байгуулагдах сургалт, хурал, зөвлөгөөний тухай мэдээллээр хангаж, тус үйл ажиллагаанд багийн мэргэжилтэнг оролцуулна.

Хоёр. Зоонозын халдвар хариуцсан багаас хэрэгжүүлэх ажлын чиг үүрэг

2.1 Урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Хариуцсан зоонозын халдварын чиглэлээр улсын хэмжээнд зоонозын өвчний дархлаажуулалт, сургалт, сурталчилгаа, тандалт судалгааг нотолгоонд суурилан төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, дүгнэлт гаргах, тайлагнах

2.1.1 Эрүүл мэндийн болон холбогдох байгууллагууд, олон нийтийг хариуцсан халдвараас урьдчилан сэргийлэх тухай бодит мэдээ, мэдээллээр хангах

2.1.2 Тухайн өвчний чиглэлээр хийсэн тандалт судалгааны аргачлал боловсруулах, судалгаа хийх, нэгдсэн үр дүнг тооцох, ашиглах, тандалт судалгааг оновчтой зохион байгуулах

2.1.3 Байгалийн голомт хяналтын шинжилгээний олон жилийн үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, голомтын төлөв байдалд үнэлгээ хийж, өвчлөлийн цаашдын хандлагыг тодорхойлох

2.2 Лабораторийн оношилгоо, шинжилгээний чиглэлээр:

2.2.1 Хариуцсан зоонозын халдварын судалгааны чиглэлээр нарийвчилсан шинжилгээг гүйцэтгэх, аргачлал боловсруулах

2.2.2 Хариуцсан зоонозын халдварын судалгааны чиглэлээр шаардлагатай нөхцөл байдал үүссэн үед лабораторийн оношилгоо, шинжилгээний чиглэлээр зөвлөн туслах (*Сарын дуудлагын онош тодруулах шинжилгээг гүйцэтгэхгүй*)

3.3 Хариу арга хэмжээний чиглэлээр:

3.3.1 Хариуцсан зоонозын халдварын дэгдэлтийн голомтод тусламж, үйлчилгээ үзүүлэх болон хариу арга хэмжээ, эрсдэлийн харилцаа холбоог зохион байгуулахад суурь мэдээ мэдээллээр хангах

3.3.2 Шаардлагатай тохиолдолд хариуцсан зоонозын халдварын дэгдэлтийн голомтод дайчлагдан ажиллах, тохирсон хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх

3.4 Эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр:

3.4.1 Хариуцсан зоонозын халдварын чиглэлээр гадаад, дотоод (мэргэжлийн байгууллага, нийгэмлэг, холбоо, төрийн бус байгууллага г.м)-ын байгууллагуудтай хамтарч ажиллах, шинэ санаачилга гаргах, судалгааны аргачлал боловсруулж батлуулах

3.4.2 Төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх

3.4.3 Тухайн өвчний холбогдолтой олон улсын байгууллагын гарын авлага, зөвлөмж, бодлогын баримт бичиг, илтгэл, өгүүлэл, ном сэтгүүлийн материалыг орчуулах, ашиглах, нийтийн хүртээл болгох

3.5 Салбар хоорондын хамтын ажиллагааны чиглэлээр:

3.5.1 Мэдээ, мэдээлэл солилцох, мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх

3.5.2 Салбар хоорондын мэргэшсэн багийн хамт тухайн өвчний талаарх суурь мэдээллийг нэгтгэн дүгнэж үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж хамтран ажиллах,

3.5.3 Хүн, малын өвчлөлийн тохиолдол бүртгэгдсэн үед эрсдэлийн үнэлгээ хийж, хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, зөвлөмжийг боловсруулах

Дөрөв. Зоонозын халдвар хариуцсан багийн
удирдлага, зохион байгуулалт

4.1 Зоонозын халдвар хариуцсан багийн ахлагчийн эрх, үүрэг

4.1.1 Бусад байгууллага, албан тушаалтны өмнө тухайн багийг төлөөлөн шийдвэр гаргах, хэрэгжүүлэх

4.1.2 Багийн үйл ажиллагаа, хурал удирдан зохион байгуулах

4.1.3 Багийн гишүүдийг өөрчлөх асуудлаар санал, үндэслэлээ холбогдох албан тушаалтанд тавих

4.1.4 Багийн тухайн жилд хийх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах, тайланг нэгтгэн хагас, бүтэн жилээр Чанар, аюулгүй байдал, хяналт үнэлгээний албаар үнэлүүлнэ

4.1.5 Хариуцсан зоонозын халдвараар хэлэлцүүлэг зохион байгуулах

4.1.6 Хариуцсан зоонозын халдварын чиглэлээр бүртгэгдсэн үйл явдал, дэгдэлтийн үед эрсдэлийн үнэлгээ хийхэд багийн оролцоог удирдан зохион байгуулах

4.1.7 Хариуцсан зоонозын халдварын холбогдолтой эрх зүйн орчны хүрээнд баримт бичиг (Стандарт ажиллагааны заавар, стандарт, заавар, журам, удирдамж)-үүд шинэчлэн боловсруулахад санал өгөх

4.1.8 Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл хэлэлцүүлж, нийтлүүлэх

4.2 Мэргэжлийн багийн гишүүдийн эрх, үүрэг

4.2.1 Хариуцсан зоонозын халдварын чиглэлээр мэдээлэл цуглуулах, боловсруулалт хийх, дүгнэлт гаргаж, мэдээлэх

4.2.2 Эрсдэлийн үнэлгээний аргачлал, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээний бодлого чиглэлийг тодорхойлох

4.2.3 Зоонозын халдварын тандалт, үүсгэгчийн оношилгооны арга, технологид өөрчлөлт гаргаж, цаашдын чиглэлийг тодорхойлох

4.2.4 Хариуцсан халдварын чиглэлээр бүртгэгдсэн үйл явдал, дэгдэлтийн үед холбогдох суурь мэдээллээр ханган эрсдэлийн үнэлгээ хийхэд оролцох

4.2.5 Хариуцсан халдварын холбогдолтой эрх зүйн орчны хүрээнд баримт бичиг (Стандарт ажиллагааны заавар, стандарт, заавар, журам, удирдамж)-үүд боловсруулах, шинэчлэн батлуулах

4.2.6 Төвийн болон салбарын хэмжээнд ашиглах, тухайн өвчний холбогдолтой цахим санг баяжуулж, эргэн мэдээллийн тогтолцоонд идэвхтэй оролцох

4.2.7 Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл хэлэлцүүлж, нийтлүүлэх

Тав. Зоонозын халдвар хариуцсан багийн
үйл ажиллагаанаас гарах үр дүн

5.1 Хариуцсан зоонозын халдварын чиглэлээр улсын хэмжээнд зоонозын өвчний дархлаажуулалт, сургалт, сурталчилгаа, тандалт судалгааны аргачлал, технологид өөрчлөлт гаргаж, цаашдын чиглэлийг тодорхойлсон байна.

5.2 Лабораторийн оношилгоо, шинжилгээний чиглэлд өөрчлөлт гаргаж цаашдын чиглэлийг тодорхойлсон байна.

5.3 Төвийн болон салбарын хэмжээнд ашиглах, тухайн зоонозын халдварын холбогдолтой цахим санг баяжуулж, эргэн мэдээллийн тогтолцоонд идэвхтэй оролцсон байна.

5.4 Эрдэм шинжилгээний бүтээлүүд (илтгэл, өгүүлэл, нэг сэдэвт бүтээл, зохиогчийн эрх)-ийн тоо, чанар өссөн байна.

5.5 Хариуцсан зоонозын халдварын холбогдолтой эрх зүйн орчны хүрээнд баримт бичиг (Стандарт ажиллагааны заавар, стандарт, заавар, журам, удирдамж) нэмэгдэж, шинэчлэгдсэн байна.

Зургаа. Зоонозын халдвар хариуцсан багийн
үйл ажиллагааг үнэлэх, арга зүй

6.1 Багийн үйл ажиллагааг төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл, багийн гишүүдийн идэвхи оролцоог харгалзан чанар, үр дүнд үндэслэн "Мэргэжлийн багийн үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлт"-ийн дагуу багийн ахлагч жилийн эцсийн тайланг 11 дүгээр сарын 20-ны дотор өөрийн үнэлгээг гүйцэтгэлийн хувиар хийж, Чанарын албаар баталгаажуулан үнэлнэ.

6.2 Чанар, аюулгүй байдал, хяналт үнэлгээний алба багийн ахлагчийн үнэлгээг баталгаажуулан үнэлж, багийн гишүүдийг урамшуулах саналыг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

6.3 Чанарын албаны баталгаажуулсан үнэлгээний нийлбэрийг 10-д хувааж дундаж үнэлгээний хувийг тооцно.

2. "Сайн" 80- 89.0 хувь
3. "Хангалттай" 70-79.0 хувь
4. "Дутагдалтай" 60-69.0 хувь
5. "Хангалтгүй" 0-59.0 хувь гэж үнэлнэ.

**ЗООНОЗЫН ХАЛДВАР ХАРИУЦСАН БАГИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

Үйл ажиллагааны чиглэл	№	Шалгуур үзүүлэлт	Багийн ахлагчийн үнэлгээний хувь	Чанарын албаны баталгаажуулсан үнэлгээний хувь
Урьдчилан сэргийлэлт	1	Хариуцсан зоонозын халдварын дархлаажуулалтын хувь		
	2	Хариуцсан зоонозын өвчний сургалт, сурталчилгааны төлөвлөгөөний биелэлт		
	3	Тандалт судалгааны үр дүн, гүйцэтгэл		
Лабдаторийн оношилгоо, шинжилгээ	4	Хариуцсан зоонозын өвчний хэдэн хувьд оношилгоо шинжилгээ хийсэн.		
Хариу арга хэмжээ	5	Суурь мэдээ, мэдээлэл бүрдүүлэлт хариуцсан зоонозын халдварын хэдэн хувийг хамарсан.		
Эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр	6	Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл хэвлүүлэхэд багийн гишүүдийн хэдэн хувь нь оролцсон		
	7	Судалгааны төсөл хэрэгжүүлсэн, оролцсон эсэх		
Салбар хоорондын хамтын ажиллагааны чиглэлээр	8	Төвийн болон салбарын хэмжээнд ашиглах, тухайн зоонозын халдварын холбогдолтой цахим санг баяжуулж, эргэн мэдээллийн тогтолцоонд идэвхтэй оролцсон байдал		
Багийн ахлагчийн үйл ажиллагаа	9	Журамд тусгасан үүргийг биелүүлсэн хувь		
Багийн гишүүдийн оролцоо	10	Гишүүн бүрийн журамд тусгасан үүргийг биелүүлсэн хувийг гаргаж, дунджаар тооцно.		
Дундаж үнэлгээний хувь				

**Долоо. Зоонозын халдвар хариуцсан
багийн гишүүдийг урамшуулах**

7.1 Дундаж үнэлгээ 79,9 хувь хүртэл гүйцэтгэлтэй үнэлэгдсэн тохиолдолд урамшуулал олгогдохгүй бөгөөд цаашид багийн үйл ажиллагааг сайжруулах талаар зөвлөмж өгнө.

7.2 Дундаж үнэлгээ 80-89.9 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн тохиолдолд сарын үндсэн цалингийн 10%-аар урамшуулал олгоно.

7.3 Дундаж үнэлгээ 90-100% гүйцэтгэлтэй үнэлэгдсэн тохиолдолд сарын үндсэн цалингийн 20%-аар тооцож, урамшуулал олгоно.

7.4 Урамшуулах хариуцлага тооцох шийдвэрийг төвийн удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

7.5 Тухайн баг, багийн гишүүдийн шинээр санаачилсан ажил нь оюуны өмчийн эрх авсан, дэвшилтэт технологийн шийдэл болсон нь эрх бүхий байгууллагаар баталгаажсан эсвэл боловсруулсан төсөл, хөтөлбөр үндэсний түвшинд хэрэгжсэн, төвийн хэмжээнд нэг зуун сая төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалтыг татсан тохиолдолд нэг сарын үндсэн цалингаар урамшуулна.

Найм. Хариуцлага

8.1 Багийн ажлаа бүтэн жилээр тайлагнаж үнэлгээ хийлгэнэ.

8.2 Багийн гишүүдийн мэргэжлийн үйл ажиллагааг эрхлэхэд гарсан алдаа, зөрчлийг холбогдох хууль тогтоомж, төвийн дотоод журмаар зохицуулна.

מחלקת/ מנהל/ מנהל
מנהל/ מנהל/ מנהל



מחלקת/ מנהל/ מנהל

מנהל/ מנהל/ מנהל

מנהל/ מנהל/ מנהל

מנהל/ מנהל/ מנהל

מנהל/ מנהל/ מנהל

מנהל/ מנהל/ מנהל

מנהל/ מנהל/ מנהל

מנהל/ מנהל/ מנהל

מנהל/ מנהל/ מנהל

מנהל/ מנהל/ מנהל

מנהל/ מנהל/ מנהל

מנהל/ מנהל/ מנהל

מנהל/ מנהל/ מנהל

מנהל/ מנהל/ מנהל

מנהל/ מנהל/ מנהל

מנהל/ מנהל/ מנהל

מנהל/ מנהל/ מנהל

מנהל/ מנהל/ מנהל

מנהל/ מנהל/ מנהל

מנהל/ מנהל/ מנהל

מנהל/ מנהל/ מנהל

מנהל/ מנהל/ מנהל



מנהל/ מנהל/ מנהל

מנהל/ מנהל/ מנהל

מנהל/ מנהל/ מנהל